

**ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН 2015 ОНЫ ЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**  
/2015 оны IV улирлын байдлаар/

Тус хэлтэс нь 2015 оны IV улирлын байдлаар дараах ажлуудыг хийж гийцэтгэсэн байна. Үүнд:

**Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:**

1. УБЕГ-ын 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний 5 сарын йл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
2. Ерөнхий газрын дотоод газар, хэлтсийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, 2015 оны үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэх сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийсэн;
3. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, 2015 оны үйл ажиллагаанд эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийсэн;
4. “УБЕГ-ын 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Газар, хэлтсийн 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөлд урьдчилан сэргийлэх (проспектив) үнэлгээ хийсэн;
5. Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
6. УБЕГ-т хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөр, төслийн биелэлтэд 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
7. УБЕГ-ын 2014 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд 2014 оны жилийн эцсийн байдлаар, УБЕГ-ын 2015 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
8. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
9. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
10. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
11. Холбогдох эрх зүйн актын биелэлтэд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;

12. УБЕГ-ын бичиг хэрэг, баримт бичгийн стандартын хэрэгжилтэд 2015 оны I, III улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийсэн;
13. Тус газрын үйл ажиллагаанд хамаарах нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад 2014, оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
14. УБЕГ-ын 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн;
15. УБЕГ-ын даргын баталсан зарим төрлийн тушаал /дүрэм, журам, бусад/ шийдвэрийн хэрэгжилтэд 2015 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
16. Гадаадын хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн бүртгэлийн газрын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийсэн.

**Хоёр. Дотоод аудитын ажлын хүрээнд:**

Санхүүгийн үйл ажиллагааны аудитын чиглэлээр:

1. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь, Орхон, Булган, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн;
2. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Говь-Алтай, Увс, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн.
3. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн.
4. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит хийсэн.

Үйл ажиллагааны аудитын чиглэлээр:

1. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “УБТАГ-ын Иргэний баримтын архивын цахимжуулалтын үйл ажиллагаа”-нд дотоод аудит хийсэн;
2. УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “Эд хөрөнгийн бүртгэл, цахимжуулалтын газрын үйл ажиллагаа”-нд дотоод аудит хийсэн.

Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр:

1. УБЕГ-ын үйл ажиллагаанд 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жилийн байдлаар эрсдэлийн үнэлгээ хийсэн;
2. УБЕГ-ын дотоод газар хэлтсүүдийн үйл ажиллагаанд тухайн газар, хэлтсийн холбогдох албан хаагчидтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийсэн;
3. 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн.
4. Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- УБЕГ-ын төв, орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн сургалт, зөвлөгөөний үеэр Удирдлагын академийн багш Д.Ганбаярыг урьж “Байгууллагад эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг удирдах ажилтнуудад;
- УБЕГ-ын төв, орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн сургалт, зөвлөгөөний үеэр Хууль зүйн яамны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Рэнцэнбямба, мэргэжилтэн Т.Төмөр-Очир нарыг урьж “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” сэдэвт сургалтыг удирдах ажилтнуудад;
- Дотоод аудитын хэлтсээс “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” сэдэвт сургалтыг дотоод газар, хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, улсын ахлах бүртгэгч нарт тус тус зохион байгуулсан.

#### Тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих зорилгоор УБЕГ-ын даргын 2015 оны 467 дугаар тушаалаар байгуулагдсан “Үнэлгээний хороо”-ны бүрэлдэхүүнд тус хэлтсийн холбогдох албан хаагчид ажиллаж, худалдан авах үйл ажиллагаа нь хуулийн дагуу үнэн зөв явагдаж байгаа эсэхэд хяналт тавин ажилласан.

#### Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр:

- Үндэсний аудитын газраас УБЕГ-ын газар, хэлтсүүдийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, илэрсэн зөрчилүүдийг арилгах үүднээс өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавин ажилласан.

#### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр:

- Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

#### Бусад чиглэлээр:

Иргэний цахим інэмлэх хэвлэх, олгох ййл ажиллагаа, цахим үнэмлэхийн сар бүрийн мэдээнд байнга хяналт тавьж ажилласан.

Дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан бусад ажлуудыг холбогдох дүрэм, журам, төлөвлөгөөнд заасан хугацаанд хэрэгжүүлэн ажилласан.

## **ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**